

Golomt Capital®

# Валютын зах зээлийн ТОЙМ

ГОЛОМТ КАПИТАЛ ҮЦК ХХК- Д БЭЛТГЭВ

2022.08.15

*Дотоодын зах зээл  
Олон улсын зах зээл*

## ДОТООДЫН ВАЛЮТЫН ЗАХ ЗЭЭЛИЙН СУУРЬ ҮЗҮҮЛЭЛТҮҮД

2022 он 08 сарын 15

Ханшийн өөрчлөлт	Албан ханш	Долоо хоног	Оны эхнээс	Жил
	3,183.00	0.179%	11.723%	11.727%

**Товч дүгнэлт:**


Өнгөрсөн долоо хоногт ам.долларын ханш төгрөгийн эсрэг 0.179 хувиар чангарлаа. Төв банк оны эхний 4 сард интервенцийн хэмжээг нэмэгдүүлээд байсан бол 5, 6 сараас эхлэн бууруулж байна. Тодруулбал 2022 оны эхний дөрвөн сард сар бүр дунджаар 560-680 сая ам.долларын интервенц хийж ирсэн бол 5 сард 388 сая, 6 сард 374 сая, 7 сард 442 сая ам.долларын интервенц хийжээ.

**Монголбанкны дуудлага худалдаа:**

Өнгөрсөн долоо хоногт Монголбанк банкнуудын 134 сая ам.доллар худалдан авах хүсэлтийг зах зээлд нэг ханшаар нийлүүлсэн байна. Харин банкууд 4 сая болон 2 сая ам.доллартай тэнцэх төгрөгийн форвард хэлцэл байгуулах санал ирүүлсэн боловч саналыг биелүүлээгүй байна.

**Гадаад худалдаа:**

Өнгөрсөн долоо хоногт БНХАУ-ын гадаад хэргийн сайд Ван И Монгол улсад айлчиллаа. Айлчлалын үеэр БНХАУ Монгол улсаас нүүрс худалдан авах урт хугацааны гэрээ байгуулж байгаагаа мэдэгдлээ. Мөн Гашуунсухайт Ганцмод боомтын төмөр замын цэгийг тогтлоо.



**Мэдэгдэл:** Энэхүү судалгаанд дурьдагдсан аливаа таамаглал нь зөвхөн мэдээллийн зорилготой бөгөөд аливаа хөрөнгө оруулалт, арилжаа хийхийг ятгасан, санал болгосон үйлдэл биш болно. Энэхүү судалгаанд дурьдагдсан таамаглалаас үүдэн гарах аливаа эрсдэлийг шинжээчи болон компани хариуцахгүй болно. Энэхүү тойм, судалгаа, таамаглалыг зөвхөн өөртөө зориулан ашиглаж, бусдад түгээн олшруулахыг хатуу хориглоно.

## ОЛОН УЛСЫН ВАЛЮТЫН ЗАХ ЗЭЭЛИЙН ТОЙМ

2022 оны 8-р сарын 15

	Хаалтын ханш	7 хоног	1 сар	1 жил
DXY	105.55	-0.72%	-1.47%	13.97%
EURUSD	1.0251	0.61%	1.69%	-12.91%
USDCNY	6.7497	0.11%	-0.09%	4.27%
USDRUB	60.605	-0.25%	6.02%	-17.26%
USDJPY	133.29	-0.14%	-3.78%	22.03%
AUDUSD	0.7115	0.02%	1.92%	-2.93%

## DXY ханшийн хөдөлгөөн:

Өнгөрсөн долоо хоногт ам.долларын ханш олон улсын зах зээл дээр голлох валютуудын эсрэг сулрах хөдөлгөөн үзүүлээ. Ханшийн өөрчлөлтөд дараах хүчин зүйлс голлон нөлөөллөө.

- Ам.долларын ханш сулархад өнгөрсөн долоо хоногийн АНУ-ын инфляцын тоон мэдээлэл таамаглаж байснаас бага гарсан нь нөлөөллөө. Өнгөрсөн долоо хоногийн лхагва гарагт АНУ-ын 7 сарын хэрэглээний үнийн индексийн тоон мэдээлэл гарлаа. 7 сард хэрэглээний үнийн индексийг шинжээчид 8.7 хувь гарна гэж таамаглаж байсан бол 8.5 хувь гарлаа. Энэ нь 6 сард гарсан 9.1 хувиас даруй 0.6 хувиар бага гарлаа. Инфляцын тоон мэдээлэл эерэг гарч байгаатай холбоотой Холбооны нөөцийн сан ирэх 9 сард болох нээлттэй захын хурлаар бодлогын хүүг 0.5 хувиар өсгөх төлөвтэй гэсэн шинжээчдийн таамаглалаас шалтгаалан ам.долларын ханш уналаа.

## График 3 : DXY /ам.долларын индекс/-ийн 7 хоногийн лаа

Published on Investing.com, 15/Aug/2022 - 2:25:00 GMT. Powered by TradingView.  
US Dollar Index Futures, (CFD):DX, D



**Мэдэгдэл:** Энэхүү судалгаанд дурьдагдсан аливаа таамаглал нь зөвхөн мэдээллийн зорилготой бөгөөд аливаа хөрөнгө оруулалт, арилжаа хийхийг ятгасан, санал болгосон үйлдэл биш болно. Энэхүү судалгаанд дурьдагдсан таамаглалаас үүдэн гарах аливаа эрсдэлийг шинжээчи болон компани хариуцахгүй болно. Энэхүү тойм, судалгаа, таамаглалыг зөвхөн өөртөө зориулан ашиглаж, бусдад түгээн олшруулахыг хатуу хориглоно.